

ЭРХЭМ ЗОРИЛГО

Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж үйлчлүүлэгчдийн тав тухтай, аюулгүй, сэтгэл ханамжтай орчныг бий болгох, чадварлаг мэргэшсэн хамт олныг бүрдүүлэх, олон улсын стандартад нийцсэн шинэ цэнгэлдэх хүрээлэн болно.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Орчны шинжилгээний үр дүнд тулгуурлан стратегийн зорилгыг тодорхойлов.

1. Барилга байгууламж, объект, техник тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэн засварлаж, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх.
2. Үйлчилгээний чанар, хүртээмжийг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.
3. Байгууллагын маркетинг, менежмент, удирдлага зохион байгуулалтыг бодлогоор чиглүүлэн, байгууллагын хүний нөөц чадавхыг сайжруулан тогтвортой хөгжилд тэмүүлэх
4. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт дурдсан шууд болон дам хамаарах үйл ажиллагааны хүрээнд холбогдогч этгээдтэй хамтран ажиллаж Монгол Улсын хөгжилд зохих хувь нэмрийг оруулах
5. Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

□ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

- Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд стратегийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон.
-
- **Зорилго 1:** Барилга байгууламж, объект, техник тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэн засварлаж, үзэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх.
- **Зорилт 1.1:** 2025–2027 онд үндсэн барилга байгууламж, объект, тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар шинэчилж, барилгын норм дүрэм, стандарт шаардлагад нийцүүлэх.
- **Зорилт 1.2:** 2027-2028 онд дээврийн хийцийг шинэчлэх зардлын тооцоо судалгааг хийж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, үе шаттайгаар засварын ажлыг эхлүүлэхээр зорих.
-
- **Зорилго 2:** Үйлчилгээний чанар, хүртээмжийг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

- **Зорилт 2.1:** Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Үндэсний их баяр наадам, соёл урлагийн арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь чанартай зохион байгуулна.
- **Зорилт 2.2:** Байгууллагын объектуудын бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийлгэснээр үйлчлүүлэгчийн эрүүл ахуйн шаардлага хангагдана.
-
- **Зорилго 3:** Байгууллагын удирдлага менежмент, маркетинг, санхүүгийн сахилга зохион байгуулалтыг бодлогоор чиглүүлэн, байгууллагын хүний нөөц чадавхыг сайжруулах.
- **Зорилт 3.1:** Байгууллагын үйл ажиллагааг бодлогоор чиглүүлж, үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.
- **Зорилт 3.2:** Байгууллагын үйл ажиллагаанд маркетингийн оновчтой шийдлийг хэрэгжүүлнэ.
- **Зорилт 3.3:** Байгууллагын хүний нөөцийг сургалт, хөгжлийн бодлогоор дэмжиж байгууллагыг чадавхжуулна.
-
- **Зорилго 4:** “Алсын хараа-2050” бодлогын баримт /2-р хавсралтын 9.3.48 дахь заалт/-д шууд болон дам хамаарах үйл ажиллагааны хүрээнд холбогдогч этгээдтэй хамтран ажиллаж Монгол Улсын хөгжилд зохих хувь нэмэр оруулах.
- **Зорилт 4.1:** Бодлогын баримт бичигт туссан байгууллагын үйл ажиллагаанд холбогдогч этгээдтэй холбоо тогтоон хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг тохиролцоно.
- **Зорилт 4.2:** Шинэ цэнгэлдэх хүрээлэн байгуулах судалгаа, барих газрын асуудлыг шийдвэрлүүлж, урьдчилсан ТЭЗҮ хийлгэнэ.
- **Зорилт 4.3:** Шинэ цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулах төслийг сонирхогч талуудтай санал солилцох, сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгийг бэлтгэх.
- **Зорилго 5:** Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх.
- **Зорилт 5.1:** Зорилго, алсын хараа стратегийг сайжруулна.
- **Зорилт 5.2:** Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ.
- **Зорилт 5.3:** Оролцогч талуудын оролцоог хангана.

- **Зорилт 5.4:** Тогтвортой үнэ цэнийг бий болгоно.
- **Зорилт 5.5:** Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулна.
- **Зорилт 5.6:** Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлнэ.
- **Зорилт 5.7:** Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл